МОНГОЛ УЛСЫН
АЖ ҮЙЛДВЭР,
ЭРДЭС БАЯЛГИЙН САЙД

Засгийн газрын II байр, Нэгдсэн үндэстний гудамж 5/1,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: (976-51) 26 35 06,
Цахим шуудан: info@mimr.gov.mn,
Цахим хуудас: www.mimr.gov.mn

2025.01.15 № 01/118

танай 2024.12.21-ны № 22 -т

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН С.ГАНБААТАР ТАНАА**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн, УИХ-ын гишүүн Танаас ирүүлсэн асуултын хариуг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 19 хуудастай.

Ц.ТУВААН

1508 08 0054

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 202 5
оны 01 сарын 15-ны өдрийн 9/// дүгээр албан
бичгийн хавсралт

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН С.ГАНБААТАРЫН ГЕОЛОГИ, ХАЙГУУЛЫН САЛБАРТ БАРИМТЛАХ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЛААРХ АСУУЛТЫН ХАРИУ

1. Геологи, хайгуулын салбарын өнөөгийн удирдлага зохион байгуулалтын нөхцөл байдал, судалгааны түвшин, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар:

1.1. Салбарын өнөөгийн удирдлага, зохион байгуулалтын нөхцөл байдал:

Ардын Засгийн газрын 1921 оны шийдвэрээр Судар бичгийн хүрээлэнгийн Газарзүйн тасагт геологийн секцийг байгуулснаар Монгол Улсын нутаг дэвсгэрт орчин үеийн онолын дагуу геологийн судалгаа, эрэл хайгуулын ажил явуулах албан ёсны бүтэц, зохион байгуулалтын суурь тавигдсан. Тус хүрээлэн нь геологийн судалгааг бие даан явуулах нөхцөл боломжгүй байсан. Иймд Ардын Засгийн газраас туслалцаа үзүүлэхийг ЗХУ-аас хүссэн. ЗХУ-ын Ардын комиссаруудын газар Монголын Засгийн газрын хүсэлтийг хүлээн авч, эрдэмтэн И.П.Рачковскийгоор удирдуулсан геологийн анхны экспедицийг Зөвлөлтийн ШУА-иас зохион байгуулж, Монгол Улсад 1923 онд илгээснээр орчин цагийн геологийн судалгаа шинжилгээний ажлыг Монголын нутагт системтэйгээр гүйцэтгэж эхэлсэн түүхтэй. Энэ үеэс эхлэн зөвлөлтийн геологичид монгол орны дорнод хэсэг болон говийн нутгуудаар маршрутын судалгаа явуулж геологийн тогтоц, ашигт малтмал, газар доорх усны тухай анхдагч материалыг цуглуулсны зэрэгцээ нүүрс, төмөр, хар тугалга, цайр зэрэг ашигт малтмалын олон тооны илрэлийг анх тогтоосон.

БНМАУ-ын Ардын Сайд нарын Зөвлөлийн 1939 оны 10 дугаар сарын 6-ны өдрийн 38 дугаар хуралдаанаар "...Улсын бүх чулуун нүүрсний үйлдвэр ба алтны уурхайг эрхлэн удирдах хийгээд түүнчлэн үйлдвэрийн төрөл бүрийн ашигт малтмалын түүхий эд болон түлш, бусад төрлийн ашигт малтмалуудыг эрж тэмтрэн олох, ашиглах ажлыг явуулах уурхай ба ашигт малтмалын Аж үйлдвэр ба барилгын яамны харъяанд бие даасан аж ахуйн тооцоотойгоор зохион байгуулсугай" гэж тогтоосноор Монголын Үндэсний геологийн албаны үндэс суурь тавигдсан түүхтэй бөгөөд тус трест нь ашигт малтмалын эрэл, хайгуул, ашиглалт хариуцсан улсын чанартай бие даасан анхны байгууллага болжээ.

Нийгмийн сэтгэл зүйд эрс том өөрчлөлт авчирсан 1990 он хүртэл Үндэсний геологийн алба буюу геологийн салбарыг удирдах байгууллагын нэр, түүний дотор төрийн захиргааны төв байгуулага 10, гүйцэтгэх засаглалын дэргэдэх байгууллагаар 3 удаа өөрчлөгдөж, тухайн үеийн шаардлагаар үйл ажиллагааны уялдааг ханган зохион байгуулж ажиллуулж ирсэн байна.

Зах зээлийн нийгэмд шилжсэн 1990 оноос хойш геологийн судалгааны чиг хандлага, зохион байгуулалт, өмчийн хэлбэр, санхүүжилт нь зарчмын хувьд

үндсэндээ өөрчлөгдөж хуучин маягаар ажлаа үргэжлүүлэн хийх боломжгүй болсон учир шинэ нөхцөл байдалд дасан зохицох, арга барилаа өөрчлөх амин чухал шаардлага урган гарсан. Ялангуяа, геологийн бүх төрлийн судалгаа, түүн дотроос хайгуулын бүх ажлыг улсын төсвөөс дангаараа санхүүжүүлэх боломжгүй нь тодорхой болсон.


Шинэ нөхцөл байдалд зохицуулан 1994 оны анхны Ашигт малтмалын хуулийн хүрээнд салбарын харилцааг зохицуулах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын дэргэд Улсын геологийн төвийг 1990 онд, УИХ-аас 1997 онд баталсан Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ашигт малтмалын хэрэг эрхлэх газрыг 1997 онд, Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрыг 2004-2008 онд, Ашигт малтмалын газрыг 2008 онд, Ашигт малтмал, газрын тосны газрыг 2016 онд тус тус байгуулан ажиллуулж, түүнд геологийн асуудлыг хариуцуулж ирсэн байна.

Өнөөдрийн байдлаар геологийн салбарын бодлогын асуудлыг чиг үүргийн дагуу Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам хариуцаж байна. Үүнээс: Геологийн судалгааны асуудлыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Үндэсний геологийн алба, ашигт малтмалын хайгуулын асуудлыг нь Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Ашигт малтмал, газрын тосны газар тус тус хуулиар олгосон өөрийн чиг үүргийн хүрээнд хариуцан ажиллаж байна.

Харин шингэн хэлбэрийн ашигт малтмал болох усны судалгааны асуудлыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Усны газар хариуцаж байгаа ба инженер геологийн асуудал нь тухайлсан хариуцсан төрийн захиргааны байгууллага байхгүй, нарийвчилсан зохицуулалтгүй байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 11[1] дүгээр зүйлийг хэрэгжүүлэхийн тулд УИХ-ын 2020 оны 12 дугаар тогтоолоор Үндэсний геологийн албыг байгуулахаар шийдвэрлэсний дагуу Засгийн газрын 2020 оны 230 дугаар тогтоолоор "Үндэсний геологийн алба"-ыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болгон байгуулагдсан бөгөөд түүний бүтэц нь 5 нэгж, 35 хүний орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна. Зураг 1.

Зураг 1. Үндэсний геологийн албаны бүтэц



Үндэсний геологийн алба нь Ашигт малтмалын тухай хуулийн 11^1 дүгээр зүйлд заасан:

"11^1 дүгээр зүйл.Үндэсний геологийн албаны чиг үүрэг

11^1.1.Монгол Улсын Үндэсний геологийн алба нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

11^1.1.1.Монгол Улсын нутаг дэвсгэр дээр геологи, геофизик, геохими, гидрогеологи, геоэкологийн зураглал, судалгаа, шинжилгээ хийх;

11^1.1.2.Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд ашигт малтмалын тархалтын зүй тогтол, минерагений судалгаа хийж, эрдэс баялгийн хэтийн төлөвийн үнэлгээ өгөх;

11^1.1.3.үндэсний геологи, эрдэс баялгийн мэдээллийн сан бүрдүүлэх, түүнийг баяжуулах, нууцын зэрэглэлд хамааруулснаас бусад мэдээллээр сонирхсон этгээдэд үйлчилгээ үзүүлэх;

11^1.1.4.ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэл хөтлөх, нөөцийн хөдөлгөөнийг бүртгэх.

11^1.1.5.энэ хуулийн 11.1.26-д заасан талбайн мэдээллийг үндэслэн улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологийн судалгааны үр дүнд тогтоосон ашигт малтмалын нөөц, баялаг, эрдсийн хуримтлалтай эсэхийг нягталж, талбайн геологийн мэдээллийг бэлтгэн геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

11^1.1.6.геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад талбайн мэдээллийг хүргүүлэхдээ энэ хуулийн 17.5.1, 17.7-д заасан шаардлагыг хангасан байх." гэсэн чиг үүргүүдийг ханган ажиллаж байна.

1.2. Геологийн судалгааны түвшин:

Геологийн шинжлэх ухаан нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд шинжлэх ухаан гэдэг агуулгаараа, шинжлэх ухааны судалгааны арга аргачлалын дагуу хийгдэж эхлээд 185 жил */гадны орнуудын газар зүй, геологийн нийгэмлэгүүдээс явуулж байсан судалгаа/*, төрийн шийдвэрээр геологи, ашигт малтмалын судалгаа явуулах, ашиглах асуудлыг шийдвэрлэж эхлээд 125 жил */Богд хааны зөвшөөрлөөр "Монголор" нийгэмлэг Түшээт хан, Цэцэн ханы нутагт алт олборлож эхэлсэн/*, төрийн бодлогын түвшинд геологи, хайгуулын салбарын асуудлыг авч үзэж, улсын хөгжилд дэмжлэг үзүүлэх салбар гэдэг үүднээс, тус салбарыг хөгжүүлэх, хариуцах байгууллага, түүний бүтэц зохион байгуулалтын суурийг тавьж, геологи, ашигт малтмалын судалгааг явуулж эхлсэн үеэс 103 жил */1921 онд Судар бичгийн хүрээлэнгийн Газарзүйн тасагт геологийн секцийг байгуулсан /*, Монголын Геологийн алба 1939 онд байгуулагдсанаар, геологийн салбар нь бие даан хөгжиж ирсэн цаг үеэс хойш эдүгээ 85 жил */БНМАУ-ын Ардын СнЗ-ийн 1939 оны 38 дугаар хуралдаанаар "... үйлдвэрийн төрөл бүрийн ашигт малтмалын түүхий эд болон түлш, бусад төрлийн ашигт малтмалуудыг эрж тэмтрэн олох, ашиглах ажлыг явуулах/* болсон байна.


Өнөөг хүртлэх Геологийн салбарын хөгжлийн түүхэн замналын хугацаанд улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх чиг үүргийнхээ хүрээнд Монгол орны нутаг дэвсгэрийн хэмжээнд геологи, ашигт малтмалын судалгааг системтэйгээр, үе шаттайгаар явуулж, региональ судалгаануудаар газар нутгаа амжилттай бүрхэж, жижиг, дунд масштабтайгаар геологи, ашигт малтмалын зурагнуудаа зохиож, үндэсний аюулгүй байдал, эдийн засгийн аюулгүй байдал, улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд шаардлагатай суурь мэдээллийг бэлтгэж, өөрийн хувь нэмрээ оруулж ирсэн юм.

Монгол орны нутаг дэвсгэрийн хэмжээнд нутгийн эрдэс түүхий эдийн хөгжлийн асуудлыг шийдвэрлэх, эрдэс баялгийн нөөцийн хэтийн төлөвийг үнэлэх, хүрээлэн буй орчин, гео гамшиг, байгаль хамгаалал болон газрын хэвлийн ашиглалт, олборлолттой холбоотой шийдвэр гаргахад суурь мэдээлэл болгон ашиглах зорилгоор улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны ажлыг хийж байна.

Мөн түүнчилэн геологийн талбайн судалгаа нь уул уурхайн түүхий эдийг бэлтгэх эдийн засгийн шууд үр ашгаас гадна барилга, зам зэрэг бүтээн байгуулалт болон эрүүл мэнд-нийгмийн салбарт ашиглах экологи, гүний ус болон бусад олон чиглэлд ашиглах мэдээллийг бэлтгэдэг ач холбогдолтой.


Дээр дурдсан геологийн суурь судалгааны өнөөгийн түвшнийг нутаг дэвсгэрийг бүрхсэн хувиар харьцуулан харуулбал:

Зураг 2. Геологийн судалгааны өнөөгийн түвшин /нутаг дэвсгэрийн хувиар/




Геологийн судалгааны ажилд улсын төсвөөс зарцуулсан хөрөнгийн хэмжээ жил бүр харилцан адилгүй, 2016-2023 онд жилд 9.3-27.7 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Зураг 3.

Зураг 3. Улсын төсвөөс 2016-2023 онд зарцуулсан хөрөнгийн хэмжээ /тэрбум төгрөгөөр/



Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж буй геологийн судалгааг ажлын төрөл, чиглэл зорилгоор нь ангилан үзэхэд зураглал-эрэл буюу талбайн судалгаа 59 хувийг эзлэн зонхилж байдаг онцлогтой. Зураг 4.

Зураг 4. Геологийн судалгааны ажил /төслөөр/



Харин улсын төсвөөр гүйцэтгэж буй геологийн судалгаануудыг төсвийн зарцуулалтаар үзэхэд геологийн зураглал болон эрэл, эрэл-үнэлгээний төслүүдэд 29-38 хувийг, харин бусад төрөлжсөн болон сэдэвчилсэн судалгаанд 1-10 хувийг тус тус зарцуулсан байна. Зураг 5.

Зураг 5. Төсвийн бүтэц /



Улсын төсвийн хөрөнгөөр 2020-2023 онд гүйцэтгэсэн геологийн бүх төрлийн судалгааны ажлын үр дүнд 33 төрлийн ашигт малтмалын 126 илрэл, 9 ордыг илрүүлсэн байна. Хүснэгт 1.

Хүснэгт 1. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологийн судалгааны үр дүнд илрүүлсэн орд, илрэлийн тоо

№	Ашигт малтмалын төрөл	2020 он	2021 он	2022 он		2023 он
		илрэл	Илрэл	Илрэл	Орд	илрэл
1	Алт	5	3	9		
2	Алт-цагаан тугалга			1		
3	Зэс	2	2	5		3
4	Зэс-алт			2		
5	Зэс төмөр			2		
6	Иттри-церкон			1		
7	Вольфрам	1				
8	Висмутын			1		
9	Г.Х.Э		1			
10	Молибден			1		
11	Холимог металл		1			
12	Титан		1			
13	Никель-хром		6	1		
14	Хром		1			
15	Сурьма	1				
16	Хар тугалга	2				
17	Хар тугалга-цайр			5		1
18	Марганец					1

19	Лити					1
20	Цагаан тугалга				1	
21	Хүнцэл		1			
22	Төмөр	3		3	1	6
23	Жонш			1	1	1
24	Нүүрс	1	1	3	1	
25	Перлит	1				
26	Гантиг			3		1
27	Давс	1			3	
28	Цеолит			1		
29	Гипс			2	2	
30	давс		1			
31	Өнгөлгөөний чулуу		9	1		3
32	Элс, шавар, хайрга		15	6		4
33	Кварц					1
НИЙТ		17	42	48	9	19

Мөн хугацаанд эдийн засгийн үнэлгээг гүйцэтгэсэн судалгааны үр дүнд илрүүлсэн орд, илрэлүүдийн хэмжээнд 25 төрлийн ашигт малтмалын баялгийг Р зэргээр үнэлгээгээр хүснэгтээр харуулав. Хүснэгт 2.

Хүснэгт 2. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологийн судалгааны үр дүнд илрүүлсэн ашигт малтмалын баялгийн үнэлгээ


№	Ашигт малтмалын төрөл	Хэмжих нэгж	2020 он	2021 он	2022 он	2023 он	НИЙТ
1	Алт	тонн	5.85	8.109	20.878		34.84
2	Мөнгө	тонн	0.038	36.07	10.758	3.1	46.87
3	Зэс	тонн	3750	1137524	779148	216500	1920422
4	Цайр	тонн	9840	18563	210	23600	28613
5	Ванади	тонн			2120		2120
6	Сурьма	тонн	1360			19500	1360
7	Вольфрам	тонн	272			12500	272
8	Молибден	тонн			181995	13800	181995
9	Никель	тонн			171515	8700	171515
10	Хром	тонн			526562		526562
11	Хар тугалга	тонн	2075	12150	318	17000	14543
12	Цагаан тугалга	тонн			34100		34100
13	Хүнцэл	тонн			241400	647700	241400
14	Төмөр	тонн	8275739	170025	1113175	5800000	9558939
15	Нүүрс	тонн	842180000				842180000
16	Перьлит	тонн	1300000				1300000
17	Элс	м3		86016	18000000		18086016

18	Шавар	м3		26843577	10000000	46000000	36843577
19	Зос	тонн		15000			15000
20	Гантиг	м3		6250			6250
21	Гибс	тонн			659119		659119
22	Глауберийн давс	тонн		36000	1900000		1936000
23	Өнгөлгөөний чулуу	м3			7909	30000	7909
24	Манган	тонн				53400	0
25	Шохойн чулуу	м3			153000000		153000000

Геологийн судалгааны ажлын үр дүнд илрүүлсэн хэтийн төлөв бүхий талбайд Ашигт малтмалын тухай хуулийн хүрээнд сонгон шалгаруулалтаар хайгуулын тусгай зөвшөөрлийг олгож байна.

Хайгуулын ажлыг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж байна. Хайгуулд зарцуулсан хөрөнгө оруулалт оргил үедээ 326 тэрбум төгрөгт хүрч байсан бол сүүлийн жилүүдэд 2 дахин буурсан. Тухайлбал: 2018 онд 153,3 тэрб.төг, 2019 онд 140,5 тэрб.төг, 2020 онд 122,7 тэрб.төг, 2021 онд 155,1 тэрб.төг, 2022 онд 182,6 тэрбум.төгрөгийг хувийн хэвшлээс тус тус зарцуулсан байна. Зураг 7.

Зураг 7. Хайгуулын ажлын 2016-2022 оны зардлын хэмжээ /тэрбум төгрөгөөр/



Хайгуулын ажлын үр дүнг эдийн засгийн шууд агуулга болох ашигт малтмалын нөөцөөр үнэлэх зарчимтай. Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд хувийн хөрөнгөөр гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнд 2024 оны эхний хагас жилд 10 төрлийн ашигт малтмалын 20 ордын нөөц бүртгэгдсэн байна. Хүснэгт 3

Хүснэгт 3. Улсын ашигт малтмалын нөөцийн тоо бүртгэлд 2024 онд бүртгэгдсэн нөөц

№	Ордын төрөл	Ордын тоо	Нөөц		
			Хэмжих нэгж	хүнэр/шлих	металл
1	Алт (шороо)	6	кг	472.64	422.90
2	Төмөр	1	мян.тн	685.04	211.83
	Төмөр		мян.тн		
	Цайр		мян.тн		
3	Хайлуур жонш	1	мян.тн	6,160.87	1,664.45
4	Нүүрс /чулууны үетэй/	3	сая.тн	7,216.25	7,710.97
5	Шохойн чулуу	2	мян.тн/тн		27,924.99
6	Барилгын чулуу /дайрга/	3	мян.м3		10,435.00
7	Өнгөлгөөний чулуу	1	мян.м3		15,471.79
8	Элс хайрга	1	мян.м3		1,485.52
9	Элс	1	мян.м3		1,129.32
10	Базальт	1	мян.тн		12,251.49
	НИЙТ	**20**			

Өнгөрсөн хугацаанд гүйцэтгэсэн геологи, ашигт малтмалын судалгаа эрэл, хайгуулын ажлуудын үр дүнд Монгол Улсын хэмжээнд 74 төрлөөр нийт 3135 ордын нөөц, ашигт малтмалын 102 төрлөөр нийт 8892 илрэл тогтоогдож, түүний нөөц, баялаг бүртгэгдсэн байна. Хүснэгт 4.

Хүснэгт 4. Монгол Улсын голлох ашигт малтмалын тэнцэл /2023 он/

№	Ашигт малтмалын төрөл	Ордын тоо	Хэмжих нэгж	Нөөцийн зэрэг	Нөөц
1	Алт /үндсэн/	109	кг	A+B+C	418,473.18?
2	Газрын ховор элемент	6	тн	B+C	3,099,183.85
3	Гянтболд /үндсэн/	28	тн	A+B+C	415,212.37
4	Зэс	41	мян.тн	A+B+C	59,584.85
5	Литий	2	тн	A+B+C	1,163,132.0
6	Молибден	13	тн	A+B+C	882,157.29
7	Мөнгө	6	тн	A+B+C	4,259.06
8	Төмөр	75	мян.тн	A+B+C	1,812,230.33
9	Уран	13	тн	B+C	192,200.31
10	Хар тугалга	7	мян.тн	A+B+C	947.82
11	Цайр	6	мян.тн	A+B+C	1,142.23

1.3. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар:

Монгол орны нутаг дэвсгэрийн геологийн судалгааны түвшин нь манай орон шиг томоохон газарт нутагтай ч хүн амын нягтаршил сийрэг, орчин цагийн шинжлэх ухаан, аж үйлдвэржилтээрээ залуу улсын хувьд боломжийн түвшинд байгаа ч эдийн засгийн болон үйлдвэржилтийн өнөөгийн хурдацтай цаг үед цаашид доголдож болох эрсдэлтэй гэж дүгнэж болно. Учир нь нийт нутаг дэвсгэрийн

хэмжээнд 2 километр тутмын газрын хэвлийн өнгөн хэсгийн мэдээллийг бүрэн цуглуулсан боловч 25 га тутмын мэдээлэл дөнгөж 50 хүрэхгүй хувьтай байгаа нь дараагийн Оюу толгой, Таван толгой, Эрдэнэт олдох магадлалыг 50 гаруй хувиар бууруулах магадлалтай. Мөн түүнчлэн гадаргын болон газрын доорх усны нарийвчилсан судалгааны түвшин 25 га тутмаар дөнгөж 2 хувьтай байгаа нь аймаг, орон нутагт дунджаар 84 га тутамд амьдарч байгаа 1 хүний ундны болон үйлдвэрлэлийн усны хэрэгцээг хангахуйц усны нөөцийн судалгаа 6.72 хувьтай байна. Иймд Монгол Улсын эрдэс баялгийн салбарын тэргүүлэх ач холбогдол бүхий геологийн салбарын хөгжүүлэх зорилгоор дараах цогц арга хэмжээг авах шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

1.3.1. Геологийн салбарын хууль, эрх зүйн орчинг сайжруулах:

Геологи, хайгуулын салбар нь тавигдах зорилго, зорилт хэрэгжүүлэх үйл ажиллагааны цар хүрээ, гарах үр дүнгээр хэдийгээр хоорондоо нягт хамааралтай хэдий ч геологийн судалгааг Газрын хэвлийн тухай болон Ашигт малтмалын тухай хуулиар, хатуу ашигт малтмалын хайгуулын ажлыг Ашигт малтмалын тухай хуулиар, усны судалгааг Усны тухай болон Ашигт малтмалын хуулиар, цацраг идэвхит ашигт малтмалын хайгуулыг Цөмийн энергийн тухай болон Ашигт малтмалын хуулиар, барилгын материалын хайгуулыг Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай болон Ашигт малтмалын тухай хуулиар тус тусдаа хууль, эрхзүйн зохицуулалтуудтай байдгийн улмаас бие даасан хэрэгжүүлэгч агентлагуудын чиг үүрэгт хамрагдан өнөөдрийн байдлаар Улсын хөгжлийн болон нийгэм эдийн засгийн хэтийн төлөвийн нэгдсэн бодлоготой бүрэн уялдаж чадахгүй байна.

Иймд дараах шат дараалсан арга хэмжээг авах:

- геологийн салбарын эрх зүйн харилцааг зохицуулж буй Газрын хэвлийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Цөмийн энергийн тухай хууль, Усны тухай хууль, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай болон бусад холбогдох хуулиудад байгаа давхардал, хийдэл, зөрчлүүдийг арилгаж, эрх зүйн цогц шинэчлэл хийх. Үүнийг хэрэгжүүлэх эхний арга хэмжээ нь Газрын хэвлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон түүнтэй уялдуулан нэмэлт өөрчлөлт оруулах хуулиудын төслийг боловсруулан батлуулах;

- геологийн судалгаа нь үндэсний аюулгүй байдалтай шууд холбоотой нутаг дэвсгэрийн мэдээллийг бүрдүүлдэг онцлогтой бөгөөд шинжлэх ухааны үндэслэлтэйгээр төлөвлөн хэрэгжүүлдэг, эдийн засгийн шууд өгөөжгүй боловч нийгэм-эдийн засгийн бүх салбартай уялдаатай байдаг тул улсын төсвөөр гүйцэтгэх төслийн гүйцэтгэгчийг тендерийн зарчмаар шалгаруулдаг эрх зүйн орчингоос тусад нь уян хатан харилцаагаар зохицуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх.

1.3.2. Геологийн салбарын бодлогын хэрэгжилтийг авч явах Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Үндэсний геологийн албыг бэхжүүлж, бусад улс орны геологийн албадын түвшинд хүргэх, Монгол Улсын геологийн салбарыг цаашид хөгжүүлэх, үйл ажиллагааг эрчимжүүлэх ажлын хүрээнд дараах зорилт, арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх зүй ёсны шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

• геологийн салбар дахь институцийг илүү боловсронгуй болгох, бодлого, үйл ажиллагааг уялдуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх. Өнөөдөр төрийн захиргааны чиг үүргийн байгууллагууд болох Үндэсний геологийн алба, Ашигт малтмал, газрын тосны газар, Усны газар, Шинжлэх ухааны хүрээлэнгүүд болох Геологийн хүрээлэн, Газар зүй, геоэкологийн хүрээлэн, Одон орон, геофизикийн хүрээлэн, Палеонталогийн хүрээлэнгүүд Үйлдвэрлэл, шинжилгээний ажил явуулдаг Геологийн судалгаа шинжилгээний төв ТӨҮГ болон бусад байгууллагууд үйл ажиллагаа явуулж байна. Энэхүү байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог юуны түрүүнд чиг үүргийн давхардал болон чиглэл, зорилгын уялдааг сайжруулснаар төрийн бодлого, үйл ажиллагааг чанартай, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлж, хугацаа алдах, хүч тарамдах, давхарддаг байдлыг арилгах цогц арга хэмжээг авах;

• геологийн салбарын хамрах цар хүрээ өргөн бөгөөд хүн амын суурьшил, аж ахуй эрхлэлт, үйлдвэржилт, бүтээн байгуулалт зэрэг нийгэм-эдийн засгийн бүх салбарт буюу газрын хэвлийтэй харьцаж байгаа бүх төлөөллийн төлөвлөлт, цаашдын хөгжилд геологийн судалгааны үр дүнг ашиглаж байдаг ач холбогдол бүхий онцлогтой. Тухайлбал: байгалийн гамшигт буюу геологийн процесс болох газар хөдлөл, үер ус, хөрсний гулсалт, геоэкологийн тулгамдсан асуудлуудыг тодорхойлох, үнэлэх, урьдчилан сэргийлэх үндсэн тулгуур судалгааг хийдэг инженер геологи, геогамшиг, геоэкологи, гео-орчины болон бусад төрлийн геологийн судалгааг олон улсын түвшинд гүйцэтгэж, түүнийг нэгдмэл удирдлагаар хангах явдал туйлын учир дутагдалтай байна. Зарим тохиолдолд тухайн асуудлыг хариуцах байгууллага ч байхгүй байна. Иймд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Үндэсний геологийн албаны харицуах чиг үүргийн хүрээнд эдгээр тулгамдсан асуудлыг хамруулан нэгдсэн зохион байгуулалтад төвлөрүүлэн ажилуулах арга хэмжээг авах;

• геологи, хайгуулын салбарын бодлогын хэрэгжилтийг авч явах Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Үндэсний геологийн албаны бүтэц, зохион байгуулалт, орон тоог бусад улс орны геологийн албадын түвшинд хүргэж, сайжруулахын тулд орон тоог нэмэгдүүлж, бүтцийг өргөжүүлэх;

• дэлхийн жишигт хүрсэн зайнаас тандан судлах, геохими болон геофизикийн судалгааны анхдагч тоон үр дүнг боловсруулах мэргэжлийн боловсон хүчнийг ахисан түвшинд гаргах, ажлын үр дүнг бодлого төлөвлөлт, хэрэгжилтэд байнга ашиглах зорилгоор дээрх чиглэлийн мэргэшлийн зохион байгуулалтын нэгжийг бий болгох.

1.3.3. Салбарын хүний нөөцийн асуудал:

Монгол Улсын геологийн салбар нь хөгжлийн түүхэн шатандаа улс эх орны эдийн засгийн хөгжлийн түүчээ нь болохын хувьд салбарын ажиллах боловсон хүчнийг тухайн үеийн харилцаа хамтын ажиллагаа нягт хөгжсөн орнуудын боловсрол, шинжлэх ухааны байгууллагуудыг түшиглэн өргөн хүрээнд далайцтайгаар бэлтгэдэг байсан бөгөөд энэхүү уламжлал нь нийгэм эдийн засгийн эрс шинэчлэлтэй холбоотойгоор өөрчлөгдөн дотоодын цөөн тооны дээд боловсролын байгууллагад дулдуйдах болсноор салбарын хүний нөөцийн нөхөн бүрдүүлэлт, тэдгээрийн мэргэшил, чадавхыг дээшлүүлэх үйл явц удаашрах, доголдох улмаар тасалдах нөхцөл байдал үүсээд байна. Гагцхүү Монгол Улсын хувьд ч биш олон улсын түвшинд геологи, гео-салбарын мэргэшлийн боловсон хүчний дутагдалд ороод байгаа энэ үед шинэ тутам байгуулагдсан Үндэсний

геологийн албаны болон геологийн салбарын боловсон хүчний нөөцийн нөхөн бүрдүүлэлтэд онцгой анхаарал хандуулах зайлшгүй шаардлага үүсээд байна.

Дээр дурдсан салбарын хөгжлийн оргил үед геологи, шинжилгээний анги, нэгж байгууллагуудад ажиллагсдын тоо даруй 4500 гаруй байсан нь өнөөгийн эдийн засгийн тулгуур багана болсон томоохон эрдэс баялгийн үйлдвэрлэл, боловсруулалтын голлох ордууд илрэн судлагдаж, үүцээ нээх боломжийг бүрдүүлсэн байдаг.

Гэтэл өнөөдрийн байдлаар шинээр бэлтгэгдэж байгаа боловсон хүчний тоо жил ирэх тутам 50-аас 30, 20-оос арав болон буурсаар, бэлтгэгдэн үйлдвэрлэлд шилжсэн хүний нөөцийн тоо амьжиргааны хэрэгцээ, ажил олгогчдын хомсдолтой уялдан үндсэн геологи, судалгааны ажлаас хөндийрөн бусад худалдаа, ажил, үйлчилгээний салбарууд руу чиглэн хүний нөөцийн эрс хомсдолд ороод байна.

Иймд эрдэс баялгийн салбар түүн дотроо геологи, хайгуулын салбарын шинэ боловсон хүчнийг бэлтгэх ажлыг эрчимжүүлэх, тэдгээрийн боловсролын түвшнийг ахиулах талаар ерөнхий, дээд боловсролын байгууллагуудтай хамтран ажиллаж жил бүрийн элсэгчдийн тоог тогтмол 30-50 хувиар нэмэгдүүлснээр 2028 гэхэд шинээр элсэгчдийн тоог 60-70-д хүргэх бодит зорилтыг дэвшүүлэх шаардлагатай.

Дээрх зорилтыг биелүүлэхийн тулд шинэ мэргэжилтэн бэлтгэх, бэлтгэгдсэн мэргэжилтэнг нарийн мэргэшлийн чиглэлээр давтан мэргэшүүлэх асуудалд анхаарал хандуулж, боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, шинжлэх ухааны асуудал хариуцсан байгууллага болон мэргэжлийн сургалтын байгууллагуудтай хамтран холбогдох арга хэмжээг авах нь зүйтэй.

2. Геологийн салбарын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэрэгжилтийг хэрхэн зохион байгуулж, шийдвэрлэх, хүрэх үр дүнгийн талаар:

Геологи, хайгуулын салбарын бодлого, төлөвлөлтийг сайжруулах ажлын хүрээнд нэн тэргүүнд шаардлагатай дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

2.1. Геологи, хайгуулын салбарын хөгжлийн бодлогыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ-сэргэлтийн бодлогод нийцүүлэн хүний хөгжлийн зорилтот хөтөлбөр, эдийн засгийн болон дэд бүтцийн хөгжлийн зорилтот хөтөлбөр, бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдтэй уялдуулан дунд хугацаанд төлөвлөн /10 жилээр/ боловсруулж, хэрэгжүүлэх.

2.2. Монгол Улсын "Алсын хараа-2050", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хүрээнд нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх зорилт, арга хэмжээнүүдийг дэмжих чиглэлээр дунд хугацаанд төлөвлөж дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

- Үндэсний аюулгүй байдлын бодлоготой уялдуулан хилийн дагуух геологи, ашигт малтмалын судалгааны ажлыг нэн тэргүүн хийж дуусгах,

- Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлоготой уялдуулан геологи, ашигт малтмалын судалгааны ажлууд, түүн дотроос 1:50 000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд гүйцэтгэж,

ойрын 4 жилийн хугацаанд 68-70 хувьд хүргэх, тус ажлыг хийж гүйцэтгэснээр улсын эдийн засаг, уул уурхайн салбар, аж үйлдвэрийн салбарын төлөвлөлтийг хийх суурь нөхцөл бүрдэнэ,

- Шинэ-сэргэлтийн бодлогын Боомтын сэргэлтийн хөтөлбөр /1.1.1, 1.1.5, 1.1.7, 1.2.1-1.2.3 /-тэй уялдуулан байнгын болон түр ажиллагаатай боомт орчмын геологи, ашигт малтмалын судалгаа, аялал жуулчлалын чиглэл, гео-орчны үнэлгээ, дэд бүтцийн суурь чулуулгийн эрсдэлийн үнэлгээ зэргийг Улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн өмнөх шатны геологийн төрөл бүрийн судалгаанд үндэслэн нарийвчлан гаргах зорилгоор судалгааны ажлыг гүйцэтгэх,

- Улсын аж үйлдвэрийн салбарт баримтлах бодлого, Шинэ-сэргэлтийн бодлогын Аж үйлдвэржилтийн сэргэлтийн хөтөлбөр /1.1.1, 1.1.5, 1.1.7, 1.2.1-1.2.3 /, төлөвлөлттэй уялдуулан төмрийн болон бусад сайн чанарын ган үйлдвэрлэхтэй холбоотой металл болон металл бус ашигт малтмалын эрлийн ажлыг зохион байгуулж хайгуулын шатанд шилжүүлэх,

- Шинэ-сэргэлтийн бодлогын Аж үйлдвэржилтийн сэргэлтийн хөтөлбөр /3.3.2 /-ийн дагуу Газрын тос боловсруулах үйлдвэрийн түүхий эдийн нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор газрын тос агуулж болох сав газруудын хэмжээнд геологийн судалгаа, эрэл, хайгуулын шатны ажлуудыг нарийвчлан гүйцэтгэж, нөөц бэлтгэх асуудлыг шийдвэрлэх,

- Улсын эдийн засгийг дэмжих бодлогын хүрээнд ашигт малтмалын чиглэлийн судалгаа, эрэл үнэлгээний ажлуудыг явуулж, улсын ашигт малтмалын нөөцийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах,

- Шинэ-сэргэлтийн бодлогын Хот хөдөөгийн сэргэлтийн хөтөлбөр /4.1.1, 4.1.5, 4.2.1-4.2.3, 4.3.1-4.3.3 /-ийн дагуу Улсын хот, аймаг, сум болон бусад суурьшлын бүсүүдийг дэмжиж инженер геологи, геоэкологи, гидрогеологийн судалгааг цогц байдлаар хэрэгжүүлэх,

- Улсын Бүсчилсэн хөгжлийн бодлого, төлөвлөлт болон орон нутгийн хөгжлийн бодлогыг дэмжиж /орон нутгаас санал авах байдлаар/ геологи, хайгуулын ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлэх,

- Шинэ-сэргэлтийн бодлогын Ногоон хөгжлийн сэргэлтийн хөтөлбөр /5.2.1, 5.4.1 /-ийн дагуу хүн амын аюулгүй, эрүүл амьдрах боломжийг бүрдүүлж геологийн /газар хөдлөл, хөрсний гулсалт, хөрсний бохирдол/, гео-экологийн, гидрогеологийн чиглэлийн судалгааны ажлуудыг гүйцэтгэх,

2.3. Дээр дурдагдсан томоохон зорилт, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх тулд дараах геологийн судалгааны ажлуудыг тэргүүн ээлжинд гүйцэтгэх. Үүнд:

- Улсын газар нутгийн хэмжээнд агаарын геофизикийн ажлыг 1:200,000-ны масштабаар бүрхэх ажлыг гүйцэтгэж дуусгах /нэн тэргүүнд соронзон болон гамма-спектрометр/,
- Улсын газар нутгийн хэмжээнд геохимийн ажлыг 1:200,000-ны масштабаар гүйцэтгэж, түүний нутаг дэвсгэрийн бүрхэлтийн хэмжээг 50 хувьд хүргэх,
- Улсын газар нутгийн хэмжээнд 1:50,000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын гүйцэтгэж, 68-70 хувьд хүргэх /ойрын 4жилд багтаан/,

- Улаанбаатар хот болон бусад аймаг, сумын төвүүдийн хэмжээнд гидрогеологи, геоэкологийн, инженер геологийн геологийн ажлыг холбогдох масштабаар /1:200,000–10,000-ны түвшинд/ хийж гүйцэтгэх шаардлагатай,

- Үндэсний геомэдээллийн нэгдсэн санг хөгжүүлж, цахим системийг нэвтрүүлэх ажлын хүрээнд:

➢ Үндэсний геологи, эрдэс баялгийн мэдээллийн санг геологийн суурь судалгаан мэдээллээр бүрдүүлэх, баяжуулах, бэлтгэсэн мэдээллийг интернэтийн орчинд салбарын мэргэжилтэн, судлаачид, хөрөнгө оруулагчид болон бусад бүх түвшний сонирхогчид тус бүрийн харилцан ялгаатай хэрэглээтэй уялдуулан холбогдох орчныг бүрдүүлснээр мэдээллийг түгээх, үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах тогтолцоог бий болгох.

3. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Үндэсний геологийн албаны талаар:

Геологи, хайгуулын салбарын бодлогыг хэрэгжүүлэх бүтцийг зөв болгож хөгжүүлэх асуудал олон жил яригдаж, 2014 онд Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр эрхзүйн орчин нь бүрдсэн. Гэвч хэрэгжилт хангагдахгүй явсаар Монгол Улсын Их Хурлын 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 12 тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Үндэсний геологийн алба байгуулагдаж, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 230 дугаар тогтоолоор орон тооны хязгаараа батлуулан, үйл ажиллагаагаа эхлүүлээд удаагүй байна.

Үндэсний геологийн алба байгуулагдахаас өмнө геологи, уул уурхайн салбарыг нэгтгэсэн бүтэц бүхий төрийн захиргааны байгууллага буюу Ашигт малтмалын газар/Ашигт малтмал, газрын тосны газар ажиллаж байсан. Өнгөрсөн 30 жилийн хугацаанд явж ирсэн тогтолцоог дүгнэн үзэхэд геологи, хайгуулын салбарын хөгжилд дэмжлэг болохуйц бүтэц зохион байгуулалт байж чадаагүй бөгөөд захиргааны бүтэц талаас нь явцуу байдлаар хандаж ирсэн байна.

Геологи ба уул уурхайн салбаруудын зорилго, чиглэл, хамрах хүрээ харилцан адилгүй бөгөөд зөвхөн ашигт малтмалын судалгаа буюу түүний нөөцийн асуудлаар тэдгээрийн чиг үүрэг уялдан давхцдаг. Гэтэл ашигт малтмалын асуудал нь геологийн салбарын хамарч буй өргөн цар хүрээний зөвхөн нэг хэсэг болдог онцлогтой байдаг.

Геологийн судалгааны хамрах хүрээ нь нэн өргөн бөгөөд ашигт малтмалын судалгаанаас гадна газрын хэвлийн бүрдүүлэгч хурдас чулуулаг болон түүний тогтоц, зүй тогтол болон бусад олон хам шинжийг судлах замаар эдийн засгийн бүх салбарын өнөөдрийн түвшинг үнэлэх, түүнд үндэслэн төлөвлөх болон цаашдын хөгжлийн чиглэлийг тодорхойлох зэрэг асуудлыг шийдвэрлэх үндсэн суурь мэдээллийн нэгдмэл санг бүрдүүлж байна. Энэ нь улсын болон эдийн засгийн салбаруудыг хөгжүүлэх төлөвлөлтийн стратегийг тодорхойлоход ашиглагдах төдийгүй хот суурин, хөдөө аж ахуй, мал аж ахуй, үйлдвэржүүлэлтийн асуудлууд ч хамаарна. Хүний ажиллаж, амьдрах орчины үндэс суурь нь газар, газрын хэвлий байдаг тул энэ орчин, нөхцлийг судалдаг геологийн салбараас шууд хамааралтай болгож байгаа юм. Сүүлийн жилүүдэд байгалийн гамшигт буюу геологийн процесс болох газар хөдлөл, үер ус, хөрсний гулсалт зэрэг геоэкологийн тулгамдсан асуудлуудыг тодорхойлох, үнэлэх, урьдчилан сэргийлэх асуудал амин чухал болж байна. Энэ чиглэлээр инженер геологи, геогамшиг, геоэкологи, гео-орчин, мөн хот сууринги геологи болон бусад төрлийн геологийн судалгааг олон улсын түвшинд

гүйцэтгэж, түүнийг нэгдмэл удирдлагаар хангагдахгүй байна. Мөн эдгээр тулгамдсан асуудлыг судлах хүний нөөц төдийгүй тухайн асуудлыг хариуцсан байгууллага ч байхгүй байна. Иймд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Үндэсний геологийн албаны харицах чиг үүргийн хүрээнд эдгээр тулгамдсан асуудлыг хамруулан нэгдсэн зохион байгуулалтад төвлөрүүлэн ажиллуулах арга хэмжээг авах зүй ёсны шаардлага байна.

Монгол Улсын УИХ болон Засгийн газар нь геологийн салбарыг хариуцсан төрийн захиргааны байгууллагыг өөрийн нарийн мэргэжлийн чиг үүрэгтэй байдагт үндэслэн тусад нь бие даасан бүтэц, зохион байгуулалт бүхий төрийн захиргааны байгууллага болгон асуудлыг шийдвэрлэсэн.

Өнөөдөр Төр, Засгийн газрын шийдвэрийн дагуу Үндэсний геологийн алба нь Монгол Улсын геологийн салбарын асуудлыг хариуцан үйл ажиллагаагаа явуулж байна. Үндэсний геологийн албыг татан буулгахтай холбоотой зохион байгуулалтын асуудал байхгүй бөгөөд харин цаашид салбарыг хөгжлийг хангах бодлогын хүрээнд Үндэсний геологийн албыг бэхжүүлэх цогц арга хэмжээг авна.

Мөн Үндэснийн геологийн албаны чиг үүргийн онцлогтой уялдуулан төсөв санхүүгийн хөрвөх чадвартай байх санхүүжилтийн тогтолцоог хуульд тухайлан тусгаж өгөх замаар санхүүжилтийн тогтолцоог өөр бусад төрийн байгууллагын санхүүжилтийн зарчмаас өөр байх байдлаар шийдвэрлэх боломжтой юм.

Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг төрийн өмчийн судалгаа, шинжилгээний хүрээлэнгүүд, боловсролын байгууллагуудад хөнгөвчилсөн, тэдгээрт давуу нөхцөл олгосон байдлаар гүйцэтгүүлэх зохицуулалтыг холбогдох хуульд тусгах замаар геологийн салбарын эрдэм шинжилгээний байгууллагын санхүүжилт, чадавхын асуудлыг шийдвэрлэх боломжийг эрэлхийлэх нь зүйтэй байна.

4. Үндэсний геологийн албыг татан буулгах, нэгтгэх, нийлүүлэх зэргээр бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийхдээ гадаадын улс орнуудад геологи, хайгуулын төрийн чиг үүргийг хэрэгжүүлдэг бүтцийн талаар судалсан эсэх, өөрийн улс орны нөхцөл байдал, бодлого зорилттой харьцуулж судлан дүн шинжилгээ хийсэн эсэх талаар:

Монгол Улсын геологийн салбарын хөгжил нь өнгөрсөн хугацаанд дэлхийн болон хөрш зэргэлдээ орнуудын хөгжлийн түвшинтэй зэрэгцэн ирсэн хэдий ч цаашид геологийн шинжлэх ухааны хөгжил, геологи, ашигт малтмалын судалгаа, түүний үр дүнг, эдийн засагт үзүүлэх нөлөөлөлтэй холбон ахисан түвшинд гаргах зайлшгүй шаардлага тулгараад байгаа энэ цаг үед Үндэсний геологийн албыг сэргээн байгуулж, ажиллуулаад удаагүй байна.

Монгол Улсын геологийн салбарын асуудлыг эрх олгосон холбогдох хуулийн хүрээнд хариуцаж буй Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам нь Үндэсний геологийн албыг татан буулгах, нэгтгэх, нийлүүлэх байдлаар бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийх ямар нэг албан ёсны шийдвэр гаргаагүй. Иймд энэ чиглэлээр гадаадын улс орнуудын геологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, түүний чиг үүрэг, бүтэцтэй харьцуулсан судалгааг өмнө хийгдсэн тул дахин хийх шаардлагагүй.

Ашигт малтмалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх хэсэгт Засгийн газарт олгосон "Үндэсний геологийн албa байгуулах;" гэсэн бүрэн эрхийг хэрэгжүүлэх зорилгоор 2016-2024 онд дараах судалгааг хийж, тухай бүр дүн шинжилгээ хийсэн. Үүнд:

1. Гадаадын улс орнуудын геологийн албаны чиг , үүрэг, бүтцийн харьцуулсан судалгааг ОХУ, АНУ, БНХАУ, Англи, Австрали, Финлянд, Канад, БНСУ, Норвеги, Энэтхэг гэсэн 10 улсын хэмжээнд харьцуулан судалсан. Судалгааны үр дүнд дараа дүгнэлтийг гаргасан байна.

Нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд эрдэс баялаг буюу ашигт малтмалын нөөц, баялгийн хэмжээ их, энэ чиглэлийн, ялангуяа геологийн салбар нь харьцангуй өндөр хөгжсөн орнуудын геологийн салбарын бүтэц, зохион байгуулалтыг нарийвчилан харьцуулсан судалгаагаар:

Геологийн албa нь бүтэц зохион байгуулалтын хувьд:

- Тухайн улсын геологийн бодлогыг хариуцсан Яамны шууд харъяанд байна
- Геологийн шинжлэх ухааны байгуулагуудын үйл ажиллагаа нь Геологийн албатайгаа нягт харилцаанд оршдог

Судалгаанд хамрагдсан байгууллагын хувьд нийтлэг шинж чанар нь:

- Геологийн анхан шатны судалгааг улсын төсвийн хөрөнгөөр хийж гүйцэтгэдэг.
- Геологи гэдэг ойлголтод зөвхөн геологийн салбар шинжлэх ухаанаар зогсохгүй геологи хайгуул, уурхайн үйл ажиллагаатай холбогдсон байгаль хамгаалал, байгалийн гамшгийн судалгааны хүрээг хүртэл өргөн дэлгэр хүрээг хамруулан авч үздэг.
- Геологийн албаны үндсэн үүрэг болох судалгааг шинжлэх ухааны системтэй судалгааны багууд дээр түшиглэн явагддаг.
- өөрийн гэсэн үндэсний шинжилгээ. судалгааны лабораториудтай байдаг. Гэсэн ерөнхий дүгнэлт гарсан.

2. Хуулийн үр нөлөөний үр дүнгийн судалгааг холбогдох журамд заасан аргачлалын дагуу хийсэн бөгөөд судалгааны үр дүнд дараах дүгнэлтийг өгсөн:

Дүгнэлт: "Үндэсний геологийн албa байгуулах нь Монгол орны нутаг дэвсгэрийн хэмжээнд геологийн судалгаа, шинжилгээ, үйлдвэрлэл, мэдээллийн боловсруулалтыг орчин үеийн түвшинд хүргэх, геологийн музей бүхий, ашигт малтмалын суурь судалгаа, тархалтын зүй тогтол цаашилбал ашигт малтмалын эрэл, хайгуул, лабораторийн шинжилгээний ажлыг дэс дараалалтай гүйцэтгэж, шинээр орд, илрэл нээн улсын эрдэс баялгийн санг өсгөн нэмэгдүүлэх, мэдээллийн нэгдмэл тогтолцоог бий болгосноор төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн техник, технологийн шинэчлэлийг хийж удирдлагын уялдаа холбоог бэхжүүлсэн бүтцийн оновчтой шийдэл болно.

Мөн төрийн өмчийн эд хөрөнгө, төсвийн санхүүжилтээр төрийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхэлж, геологийн судалгаа, шинжилгээний салбарын нэгдсэн удирдлагаар хангагдсанаар төсвийн зардал хэмнэгдэж, улсын төсвөөр хийгдэх ажлын чанар, үр өгөөжийг нэмэгдүүлж,

Монголын эрдэс баялгийн салбар олон улсын жишигт нийцэх, хүрэх ач холбогдолтой.

Ингэснээр геологийн зураглалын судалгаа, газрын хэвлийд байгаа ашигт малтмал, түүний чанар, тоо хэмжээг судлан тогтоож нэгдсэн үнэлгээ өгөх, хэтийн төлөв бүхий эрдсийн хуримтлал бүхий талбайг нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд ялган тогтоож хөрөнгө оруулалтын суурь орчинг бий болгох, улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн төрийн мэдлийн ашигт малтмалын орд бий болгож үнэлгээ өгөх зэргээр Үндэсний аюулгүй байдал, эдийн засгийг бэхжүүлэхэд нөлөө үзүүлж, үндэсний Геологийн салбарыг хөгжүүлэх төрийн бодлогод нийцсэн байна.Үндэсний геологийн алба нь Уул уурхайн сайдын баталсан үйл ажиллагааны дүрмээр зохицуулагдан үйл ажиллагаа явуулах бөгөөд иргэд, нийгэмд хандсан геошинжлэх ухааныг таниулах, олон улсад сурталчилахаас гадна геологийн салбарт хөрөнгө оруулалтыг татах үндсэн чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаа эрхэлнэ."

3. Чиг үүрэг, шинжилгээ, дахин хуваарилах, санхүүгийн дүн шинилгээнүүдээс бүрдэх чиг үүргийн иж бүрэн судалгааг 2019 онд, чиг үүрэг дахин хуваарилах шинжилгээг 2021 онд тус тус хийсэн. Энэхүү судалгаа, шинжилгээгээр Үндэсний геологийн албыг засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг хэлбэрээр бие даасан төрийн захиргааны байгууллага болгон зохион байгуулах, салбарын хуулиудад заасан хуулиар олгогдсон эрх, үүргийн давхардлыг арилгах шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан.

4. Байгалийн тогтоц, ашигт малтмалын хэтийн төлөвөөр Монгол Улстай ойролцоо, зарим талаар ижил төсөөтэй ОХУ, БНХАУ, Канад, Австрали зэрэг улсын геологийн салбар, түүний ашигт малтмалын салбарыг Монгол Улсын Үндэсний геологийн албанаас 2024 онд хийсэн ерөнхий үнэлгээний судалгаагаар дараах нөхцөл байдал тогтоогдсон байна. Улс тус бүрээр авч үзэхэд:

БНХАУ-ын хувьд:

- *Хөрөнгө оруулалтын чиг хандлага:* Хятад улсын геологи хайгуулын салбарт оруулсан хөрөнгө оруулалт сүүлийн жилүүдэд тогтвортой өсөлттэй. Тус улсын ашигт малтмал, газрын тос, байгалийн хийг багтаасан геологи хайгуулын салбарын хөрөнгө оруулалт нь 2024 он хүртэл гурван жил дараалан өссөн байна. (chinadaily.com.cn)

- *Гадаад дах хөрөнгө оруулалт:* Хятадын компаниуд уул уурхайн салбарт гадаад дах хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлж байна. 2023 оны эхний хагаст Хятадын металл ашигт малтмалын хайгуул болон уул уурхайн гадаад дахь хөрөнгө оруулалт 10 тэрбум ам.доллар давж, өмнөх оны мөн үеэс 131%-аар өссөн. (mining.com)

- *Стратеги:* Хөрөнгө оруулалт нь литий, кобальт, никель зэрэг эрчим хүчний шилжилтэд шаардлагатай ашигт малтмалын чиглэлийн судалгаа, хайгуулын ажилд төвлөрч байна. Энэ нь Хятадын шинэ технологийн хангамжийн сүлжээг баталгаажуулах стратегийн зорилгод нийцэж байна. (reuters.com)

- *Дотоодын хайгуулд*: Хятад улс газрын тос, байгалийн хийнээс бусад ашигт малтмалын геологи хайгуулын ажилд 2018 онд ойролцоогоор 9.28 тэрбум юань (1.34 тэрбум ам.доллар) зарцуулсан нь нийт геологи хайгуулын төсвийн 53.4%-ийг эзэлсэн байна. (chinaminingtj.org) 2019 он гэхэд Хятадын геологи хайгуулын хөрөнгө оруулалт 14.4 тэрбум ам.долларт хүрч, уул уурхайн үйл

ажиллагаанд 173 тэрбум ам.доллар зарцуулсан нь өмнөх онтой харьцуулахад 23%-аас 24%-ийн өсөлттэй байсан байна. (pubs.usgs.gov) Хятадын дотоодын геологи хайгуулын төсөв тогтвортой өсөлттэй байгаа бөгөөд энэ нь эрчим хүчний шилжилт, өндөр технологийн салбарт чухал ач холбогдолтой ховор элементүүд, литий, никель зэрэг ашигт малтмалд анхаарал хандуулж байгаатай холбоотой байна.

• *Олон улсын хөрөнгө оруулалт:* Хятадын компаниуд ашигт малтмалаар баялаг бүс нутагт их хэмжээний хөрөнгө оруулалт хийж, дэлхийн хэмжээнд байр сууриа өргөжүүлж байна. Хятад улс чухал ашигт малтмалын салбарын гинжин хэлхээн дэх байр сууриа бэхжүүлэх, баталгаажуулах зорилгоор Африк, Өмнөд Америк, Зүүн Өмнөд Азийн бүс нутагт 2023 онд литий, кобальт, никель зэрэг ашигт малтмал дээр төвлөрч, нийт 20 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн. (reuters.com)

ОХУ-ын хувьд :

• *Геологи хайгуулын салбарт:* Сүүлийн арван жилийн туршид ашигт малтмалын хайгуулын идэвхтэй үйл ажиллагааг үргэлжлүүлсээр ирсэн бөгөөд зөвхөн 2021 онд геологи хайгуулын компаниуд 839,000 тууш метр өрөмдлөг хийсэн нь идэвхтэй хайгуулын үйл ажиллагааг явуулж байгааг харуулж байна. (statista.com)

• *Гадаадын хөрөнгө оруулалт:* Орос улс геологи, хайгуулын салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг ихээр татан оролцуулах зорилгоор Хятад, Энэтхэг зэрэг орнуудаас хөрөнгө татахад нээлттэй байгаагаа 2024 оны есдүгээр сард мэдэгдсэн байна. (reuters.com)

• *Стратеги:* Орос улс өөрийн нутаг дэвсгэрт орших ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах чиглэлд идэвхтэй хөрөнгө оруулалт хийж, дэлхийн уул уурхайн салбарт өөрийн байр суурийг бэхжүүлэхийг зорьж байна. (link.springer.com)

• *Дотоодын хайгуулд:* Оросын хайгуулын төсөв 2021 онд 535 сая ам.доллароос давж, өмнөх оныхоос бараг 102 сая ам.доллароор өссөн байна. (statista.com) Газрын тос, байгалийн хийн хайгуулын ажилд оруулсан хөрөнгө оруулалт 2023 онд 300 тэрбум рубль (ойролцоогоор 3.4 тэрбум ам.доллар) байсан бол хатуу ашигт малтмалын хайгуулд 78 тэрбум рубль (ойролцоогоор 880 сая ам.доллар) зарцуулсан байна. (reuters.com)

• *Олон улсын хөрөнгө оруулалт*: Оросын компаниуд Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн (ТУХН) орнууд болон Африк тивд ашигт малтмалын хайгуул, олборлолтын төслүүдийг хэрэгжүүлсээр байгаа ч олон улсын төслүүдийн жилийн хөрөнгө оруулалтын нарийвчилсан мэдээлэл хязгаарлагдмал байна.

Канад Улсын хувьд :

• *Олон улсын хөрөнгө оруулалт:* Канадын компаниуд Латин Америк болон Африк тивд ашигт малтмалын хайгуулын төслүүдэд идэвхтэй оролцож, чухал ашигт малтмалуудыг эрж хайх, нөөцийг баталгаажуулах чиглэлээр идэвхтэй ажиллаж байна.

• *Дотоодын хайгуул:* Канадын уул уурхайн болон ашигт малтмалын хайгуулын компаниуд 2021 онд 3.8 тэрбум канад доллар, 2022 онд 4.1 тэрбум канад долларыг хайгуул болон ордын үнэлгээний төсөлд зарцуулж өссөн дүнтэй байсан бол. 2023 онд 3.7 тэрбум канад доллар болж буурсан. (natural-resources.canada.ca) Харин Канадын жижиг компаниудын хайгуулын зардал 2023 онд 2.0 тэрбум канад доллар болж, 2022 оноос 19%-аар буурсан байна. Хайгуулын 2022 оны зардалыг Канадын байгалийн баялгийн яам (Natural Resources Canada) сүүлийн жилүүдийн хамгийн өндөр үзүүлэлт гэж үзжээ(natural-resources.canada.ca)

Австрали Улсын хувьд :

• *Олон улсын хөрөнгө оруулалт*: Австралийн уул уурхайн компаниуд Африк, Зүүн Өмнөд Ази, Америкийн бүс нутагт өөрсдийн нөлөөллөө өргөжүүлж, литий, кобальт, ховор элементүүд зэрэг чухал ашигт малтмалын хайгуул хийж нөөцийг тогтоох ажилд хөрөнгө оруулалт хийсээр байна.

• *Дотоодын хайгуул*: Австрали улс дотоодын үйлдвэрлэл болон сэргээгдэх эрчим хүчийг 2023 онд дэмжихэд 22.7 тэрбум австрали доллар (ойролцоогоор 15 тэрбум ам.доллар)-ыг геологи хайгуулын ажилд төсөвлөсөн. Энэ төсөв нь өндөр технологийн түүхий эдийн хэрэгцээг гадаадын эх үүсвэрээс хамааралгүй болгоход чиглэсэн бөгөөд үүнд чухал ашигт малтмалын хайгуул болон цэвэр эрчим хүчний салбарт их хэмжээний татаас олгох, хөрөнгө оруулалтын процессыг хялбаршуулах арга хэмжээ багтаж байна. (reuters.com) Австралийн засгийн газар "Future Made in Australia" бодлогын хүрээнд ирэх 10 жилийн хугацаанд 566.1 сая ам.долларыг геологийн суурь судалгаа болон шинжлэх ухааны шинэ төслүүдийг санхүүжүүлэхэд зарцуулахаар төлөвлөж байна. Энэ нь усны нөөцийн системтэй судалгаа, далайн эргийн бүсийг илүү сайн зураглах, шинэ ашигт малтмалын орд, цэвэр устөрөгч зэрэг эрчим хүчний эх үүсвэрийг нээхэд чиглэж байна. (news.com.au)

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМ